

## Үйл үгийн нөхцөлдүүлэн холбох нөхцөл

Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр



**Үйлийн холбох нөхцөл:** Холбоо үг, өгүүлбэрийн бүтцэд орсон үйл үгийг бусад үйл үг болон нэр үгтэй холбох үүрэгтэй нөхцөлүүдийг үйлийн холбох нөхцөл гэнэ. Үйлийн холбох нөхцөлийг нөхцөлдүүлэн холбох, тодотгон холбох нөхцөл гэж хоёр ангилна.

**Нөхцөлдүүлэн холбох нөхцөл:** Үйл үндсийн дараа орж, тухайн үйл үгийг бусад үйл үгтэй холбох үүрэгтэй нөхцөлийг хэлнэ.

**Дасгал 18:** Уншсан эхэд хэрэглэсэн үйлийн нөхцөлдүүлэн холбох нөхцөлийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлоорой.

*Ажиллах эх: Тэр (үлгэрийн төгсгөл)*

**Алхам 1:** Нөхцөлдүүлэн холбох нөхцөлтэй үйл үгсийг эхээс түүж бичээд, 2, 2 үгийг бүтцээр задлаарай.

| Нөхцөл      | Жишээ | Бүтцээр задлах |
|-------------|-------|----------------|
| - ж, -ч     |       |                |
| - н         |       |                |
| - саар<br>4 |       |                |
| - н         |       |                |
| - тал4      |       |                |

Эдгээр (вал<sup>4</sup> –бал<sup>4</sup>, -магц<sup>4</sup>, - вч, - хлаар<sup>4</sup>, -нгуут, -нүүт, -нгаа<sup>4</sup>, -лгүй) нөхцөл нь нөхцөлдүүлэн холбохын нөхцөл. Ийм нөхцөлтэй үйл үг дээрх эхэд байхгүй байна.

**Алхам 2:** Дараах үгс өгүүлбэрт ямар үгтэй холбогдож байгааг олж бичээрэй.

ухаарч .....  
 өргөөд .....  
 босгон .....  
 үүрсээр .....  
 суутал .....

**Алхам 3:** Нөхцөлдүүлэн холбох нөхцөлүүд нь нэг үйл үгийг нөгөө үйл үгтэй холбохдоо ямар ямар утгыг илэрхийлж байгааг жишээгээр тайлбарлаарай.

- A. Үйл явдлууд зэрэгцэж болж байгааг .....  
 B. Үйл явдлууд дараалан болж байгааг.....  
 C. Үйл явдлууд үргэлжилж байгааг .....  
 D. Үйл явдлууд эсрэгцэж байгааг .....  
 E. Үйл явдлын шалтгааныг ( ухаарч дээдлэн хүндлэх болсон.) *Тэгэхээр –ч нөхцөлөөр дээдлэн хүндлэх болсны шалтгааны утгыг илэрхийлж, холбосон байна.*

## Үйл үгийн нөхцөлдүүлэн холбох нөхцөл

Алхам 4. Нөхцөлдүүлэн холбох нөхцөлүүдийг дэвтэртээ бичээд, тогтоогоорой.

| I бүлэг буюу зэрэгцүүлэн холбох нөхцөл |                                |
|----------------------------------------|--------------------------------|
| 1. Зэрэгцэн холбох                     | -ж, -ч                         |
| 2. Урьдчилан холбох                    | -аад, -ээд, -оод, -өөд         |
| 3. Хам холбох                          | -н                             |
| 4. Үргэлжлүүлэн холбох                 | -саар, -сээр, -соор, -сөөр     |
| II бүлэг буюу угсруулан холбох холбоос |                                |
| 5. Дутагдан холбох                     | -вч                            |
| 6. Бэлтгэн холбох                      | -магц, -мэгц, -могц, -мөгц     |
| 7. Угтан холбох                        | -тал, -тэл, -тол, -төл         |
| 8. Дагалдан холбох                     | -хлаар, -хлээр, -хлоор, -хлөөр |
| 9. Болзон холбох                       | -вал, -вэл, -вол, -вөл         |
| 10. Далимдан холбох                    | -нгуут, -нгүүт                 |
| 11. Дашрамдан холбох                   | -нгаа, -нгээ, -нгоо, -нгөө     |
| 12. Үгүйсгэх холбох                    | -лгүй                          |

**Алхам 5. Цэгийн оронд тохирох нөхцөлдүүлэн холбох нөхцөлийг нөхөж бичээрэй.**

Элсэн дээрх мөр

Нэгэн удаа би зүүд зүүдлэв. Тэр зүүдэндээ нэгэн элсэн дээр би алха... явах ба харин хажууд нь Бурхан явж байх аж. Тэнгэрт түүний туулсан амьдралын дүр зургууд дүрслэгдэ... харагдах ба дараа нь элсэн дээр хоёр хүний мөр байхыг тэр ажиглав. Нэг нь түүнийх, нөгөө нь бурханых. Түүний өмнө амьдралынх нь хамгийн сүүлчийн зураглалууд харагд... дуусахад тэр элсэн дээрх мөрийг эргэ... харав. Тэгээд түүний амьдралын ихэнх хэсэгт зөвхөн ганцхан мөр байгааг олж харав. Түүнээс гадна энэ нь түүний амьдралд хамгийн хүнд хэцүү цаг үе байсан гэдгийг анзаарав. Тэр их гунигла... бурхнаас ингэж асуув.

Хэрэв таны замаар яв... та намайг орхихгүй гэж та хэлээгүй гэж үү. Миний анзаарснаар миний амьдралын хамгийн хэцүү цаг үед элсэн дээр ганцхан л мөр харагда... байна. Таны туслалцаа хамгаас их хэрэгтэй байхад та яагаад намайг орхидог байсан бэ? Бурхан ингэж хариулав. Миний хонгорхон хүүхэд минь, би чамд хайртай. Би чамайг хэзээ ч орхихгүй. Чиний амьдралын зовлонтой бөгөөд сорилттой тэр мөчид чинь ганц л мөрний хээ харагда... байгаа нь үнэн. Учир нь тэр хүнд цаг үед би чамайг гэр дээрээ тэвэр... явж байсан юм гэжээ.

Алхам 6. Дараах үйл үгийг бүтцээр задалж бичээрэй.

- Суусаар .....
- Бодогдон .....
- Тогловол
- Харахлаар
- Үзтэл
- Хийнгээ
- Харангуут
- амьдравч